



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-6</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>7-32</i>

Өргөн мэдүүлсэн төслийн талаар мэдээлэх	8-9
1. Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх	9-17
2. “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	17-19
3. “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	19-25
4. Баталсан тогтоолын эцсийн найруулга сонсох	25
5. Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хаалтын ажиллагаа	26-32

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 31-ний өдөр /Лхагва гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Н.Учрал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 50.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 34 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Амгаланбаатар, Д.Батбаяр, Б.Батцэцэг, Д.Ганмаа, Т.Доржханд, Л.Мөнхбаатар, П.Мөнхтулга, Б.Пүрэвдорж, Б.Тулга;

Чөлөөтэй: О.Алтангэрэл, Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, О.Батнайрамдал, Х.Баттулга, П.Батчимэг, Б.Баярбаатар, Ш.Бямбасүрэн, М.Нарантуяа-Нара, Ч.Номин, О.Номинчимэг, Н.Номтойбаяр, Э.Одбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пунсалмаа, М.Сарнай, Д.Цогтбаатар, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Ж.Баярмаа, Х.Болормаа, Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Д.Ганбат, Л.Гантөмөр, С.Лүндэг, М.Мандхай, Б.Мөнхсоёл, З.Мэндсайхан, Б.Уянга, Б.Чойжилсүрэн, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: Ж.Батсуурь, Ж.Бат-Эрдэнэ, М.Ганхүлэг, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Т.Мөнхсайхан, С.Одонтуяа, Д.Пүрэвдаваа, Г.Хосбаяр;

Хоцорсон: Ч.Анар-1 цаг 34 минут, Ц.Даваасүрэн-1 цаг 20 минут, Б.Заяабал-18 минут, Ц.Мөнхтуяа-14 минут, Б.Найдалаа-18 минут, Р.Сэддорж-43 минут, Б.Түвшин-31 минут, А.Ундраа-04 минут, Б.Энхбаяр-18 минут, С.Эрдэнэбат-09 минут.

Өргөн мэдүүлсэн төслийн талаар мэдээлэх

Улсын Их Хурлын дарга Н.Учрал Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүнээс 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Төсвийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Төсвийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Төсвийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нарын 70 гишүүнээс 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн “Нийгмийн даатгалын санг хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсныг мэдээлэв.

Нэг.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг үг хэлж, хуулийн төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллаас хасах горимын санал гаргав.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Б.Жавхлан, Х.Ганхуяг, Х.Тэмүүжин нар үг хэлэв.

Н.Учрал: Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 38
Бүгд: 71
46.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 40
Бүгд: 71
43.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 39
Бүгд: 71
45.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 38
Бүгд: 71
46.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуулийн төслүүдийг гишүүдийн олонх яаралтай хэлэлцэхийг дэмжээгүй тул ердийн горимоор хэлэлцэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Учрал: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	45
Татгалзсан:	27
Бүгд:	72

62.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Ж.Баясгалан, Х.Тэмүүжин нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:27/

Уг асуудлыг 11 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, С.Бямбацогт, Б.Бейсен нар үг хэлэв.

Н.Учрал: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 29
Бүгд: 72
59.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир үг хэлэв. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:45/

Уг асуудлыг 11 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Баталсан тогтоолын эцсийн найруулга сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал баталсан тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:46/

2.“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:46/

3.“Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:46/

4.“Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:47/

Уг асуудлыг 11 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хаалтын ажиллагаа

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын

асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганыг хааж үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал үг хэлж дууссаны дараа Монгол Улсын Төрийн дууллыг “Их Хуралдай” танхимд эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсод суудлаасаа босож хүндэтгэл үзүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны урилгаар “Ахиллис Монгол клуб”-ын гишүүд, марафоны тамирчдын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 36 минут үргэлжилж, 126 гишүүнээс 74 гишүүн хүрэлцэн ирж, 58.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 34 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгаж мэндчилье. Гишүүдийн ирц 50,8 хувьд хүрсэн тул 2025 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 31-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 9 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт, Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

2 дугаарт, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

3 дугаарт, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

4 дүгээрт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

5 дугаарт, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг явуулна.

6 дугаарт, “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

7 дугаарт, “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлуудын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

8 дугаарт, Баталсан тогтоолын төслүүдийн эцсийн найруулгыг сонсоно.

9 дүгээрт, Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хаалт хийнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар та бүхэнд танилцуулъя.

1.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд;

2.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд;

3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газар 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд;

4.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Засгийн газар 12 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд;

5.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд;

“Нийгмийн даатгалын санг хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа нарын 70 гишүүн 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсныг та бүхэнд танилцуулъя.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байгаа хуулиудыг хиймэл оюунд суурилсан систем дээр дүн шинжилгээ хийж эхэлсэн. Үүнтэй холбогдуулаад энэ татварын хуулиудаар өнөөдөр хиймэл оюун дээр хүний эрхийн зөрчил, эдийн засгийн эрх чөлөө, улс төрийн эрх, эрх чөлөөний зөрчлүүдийг дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах бэлтгэл ажлыг бас хангаж байна. Тэгээд цаашид бол хууль санаачлагч нар хуулийн төслүүдийг өргөн мэдүүлэхдээ эхлээд D-Parliament дээр AI шинжилгээ рүү орж, хуулийн төслүүд дээрээ хиймэл оюуны шинжилгээ хийж хэвших хэрэгтэй. Энэ систем ажиллаж эхэлсэн байна. Хаврын чуулганы хугацаанаас авхуулаад энэ үйл ажиллагаа бол илүү тогтворжино. Хэрэглээнд нэвтэрнэ. Мөн эрдэмтэн судлаачид, эрх зүйчид хуулийн төсөлтэй холбогдуулж, мөн хиймэл оюун дээр шинжилгээгээ хийх бололцоо бүрдсэн. Мөн Их Хурлын гишүүдийн хүсэлт тавьсны дагуу та бүхэнд хийж хэрэгжүүлнэ гэж хэлсэн. Тэгээд үүний дагуу бид Засгийн газрын хэрэглэдэг нээлттэй өгөгдлийн санг Их Хурлын гишүүдэд хэрэглэх бололцоог бол хангасан. Их Хурлын гишүүд, гишүүдийн туслах, зөвлөхүүдэд сургалт зохион байгуулж байна. E-cabinet гээд Засгийн газар бол нээлттэй өгөгдлийн санг хэрэглэдэг. Яг үүнтэй адилхан E-Parliament буюу parliament.mn-ээр ороод, гишүүд өөрийнхөө админ эрхээр нэвтрээд, 99 мэдээллийг real time-р буюу бодит цагаар харах бололцоог бүрдүүлсэн.

Тэгээд үүнтэй холбогдуулаад гишүүд тоон мэдээлэл бол бодит цагаар авна. Тэгэхээр үнийн хөөрөгдөлтэй холбоотой бас Засгийн газарт өгөх чиглэл батлагдсантай холбогдуулаад аймаг, орон нутагт өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, экспорт, импортын мэдээлэл гээд бүх мэдээллийг нэмэгдсэн өртгийн албан татварын систем мөн төрийн мэдээлэл солилцооны системээс энэ мэдээллүүдийг татаж авч, Их Хурлын гишүүд өөрсдөө шууд энэ мэдээ мэдээллүүдийг харж, бодит статистик дээр дүн шинжилгээ хийх бололцоог гишүүдэд бүрдүүлсэн. Нийт 99 мэдээллийг энэ систем агуулж байна гэдгийг та бүхэнд хэлье. Тэгэхээр цаашдаа бол тоон мэдээлэлтэй холбоотой асуултуудыг заавал ажлын хэсгээс асуухгүйгээр өөрсдийн iPad, өөрсдийн device дээр ороод мэдээллүүдийг бодит цагаар харах бололцоог бүрдүүлсэн. Тэгэхээр гишүүдийг энэ системийг хэрэглэж хэвшихийг зөвлөж байна.

Хэлэлцэх асуудалдаа орно. Гишүүдийг танхимд урья.

Хуулийн төслийг яаралтай горимоор хэлэлцэхээр Засгийн газраас өргөн мэдүүлсэн. Үүнтэй холбогдуулаад санал хураалт явуулна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Уянгахишиг гишүүн горимын санал гаргана. Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл горимын санал гэхээр энэ 12 сарын 30-нд яаралтай хэлэлцүүлэх горимоор гээд Татварын хуулиуд оруулж ирсэн байна. Гэтэл яаралтай хэлэлцүүлэх гэдэг маань өөрөө үндэсний аюулгүй байдалтай холбоотой буюу үндэсний эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдолд Дэгийн тухай хуулийн 33.1-ээр яаралтай хэлэлцэх боломжтой. Гэтэл яг энэ өргөн барьсан төсөл дээр яагаад үндэсний эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөх учир шалтгаантай болчхов. Яагаад яаралтай горимоор хэлэлцэх ёстой вэ гэдэг ийм үндэслэл бол харагдахгүй байна.

Тийм учраас горимын санал энэ өнөөдрийн яаралтай хэлэлцэх эсэх гэдгийг хэлэлцэх асуудлаас хасуулах саналтай байна.

Н.Учрал: Бүтэн жилийн хугацаанд энэ Татварын багц хуулийн талаар олон нийтийн санал асуулга явагдсан. D-Parliament дээр бас тавигдсан. Тэгээд Их Хурлын гишүүд, бүлгүүд бол Засгийн газарт удаа дараа шаардсан. Иргэдэд үүсгээд байгаа энэ татварын дарамтыг багасга. Нэгэнт төсвийн хүрээгээ батлахдаа бид нар орлого, ДНБ-ий харьцааг 30 хувьд хүргэсэн. Энэ орон зайд бол өөрчлөлт хийх боломж байгаа. Тийм учраас энэ Татварын багц хуулийг баталж байж энэ орон зайд хувийн хэвшил зах зээлд оролцох бололцоог илүү тэлэх боломжийг олгох ёстой. Тэгэхээр бараг 2,7 их наяд төгрөгийн татварын ачааллыг энэ хуулиудаар бууруулж байгаа гэдэг ийм тооцоолол гарсан. Тийм учраас цаг алдалгүй энэ Татварын багц хуулийг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, Их Хурал дээр ажлын хэсэг байгуулаад чуулганы завсарлагаагаар Их Хурлын гишүүд энэ Татварын багц хуулиуд дээр ажиллая гэдэг ийм хүлээлттэйгээр энэ чуулганы хугацаанд бол гишүүд олон удаа шаардсан. Ингээд Засгийн газар өчигдөр л нэн яаралтай горимоор мэдүүлж байгаа юм.

Тийм учраас өнөөдрийн хэлэлцэх асуудалд оруулсан байгаа. Ер нь Уянгахишиг гишүүний саналаар бол санал хураах бололцоотой. Горимын санал гаргасан байна. Нэн яаралтай горимоор хэлэлцэхийг Их Хурлын гишүүд дэмжсэн тохиолдолд Байнгын хороогоор хуулийн төслийг хэлэлцэнэ. Үргэлжлээд чуулганаар хэлэлцэнэ гэсэн үг.

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дээр Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулж хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ гэж 33.1 дээр заасны дагуу Засгийн газраас хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан бичиг ирсэн. Үүнтэй холбогдуулаад Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхээ даргын зөвлөл дээр санал оруулаад, олонхын саналаар дэмжигдсэн.

Тэгэхээр хуулийнхаа дагуу та бүхэнд танилцуулж байна. Тэгээд гишүүдийн бүрэн эрх. Яаралтай хэлэлцэх эсэхийг санал хураагаад шийдвэрлэнэ. Хэрвээ яаралтай дэмжигдэхгүй бол ердийн горимоор хэлэлцэнэ гэсэн үг. Тэгэхээр чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу анхдагч хуулийн төсөл учраас өргөн барьснаас хойш 7 хоногийн хугацаагаа барина. Хэлэлцүүлэг болгон 5 хоногийн хугацаа гээд яг хуулийнхаа хугацаагаар явна л гэсэн үг. Ердийн горимоор хэлэлцэх дэмжигдвэл. Яаралтай горим дэмжигдэхгүй тохиолдолд ердийн горим руу шилжинэ. Тэгэхээр ирэх жил хаврын чуулганаас нааш хэлэлцэх бололцоогүй болно л гэсэн үг.

Тамгын газрын мэдээлж байгаагаар бол энэ 33.1 яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулаад, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ л гэж байгаа юм. Тэгэхээр хэлэлцэх эсэх хэрвээ өнөөдөр дэмжигдвэл Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдана. Тэгээд хаврын чуулганаар батлагдана л гэсэн үг. Засгийн газар одоо хуралдаж байгаа юм байна. Засгийн газраас нэг тайлбар өгөх хэрэгтэй.

Чуулганы завсарлагаагаар Их Хурлын гишүүд даргын захирамжаар байгуулагдсан 13 ажлын хэсэг “Чөлөөлье” санаачилгын хүрээнд ажиллана. Дээрээс нь гишүүд хүсэлт тавьсны дагуу хуулийн төсөл санаачлах бэлтгэл ажлыг хангачихсан байгаа. Гишүүдийн хүсэлтийн дагуу Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсгүүдийг байгуулж байгаа. Тэгэхээр 2 намын бүлгийн дарга, ХҮН намын зөвлөл, бусад улс төрийн намууд хуулийн төсөл дээр ажиллах шаардлагатай байгаа бол даргын захирамжаар ажлын хэсгүүдээ байгуулаад ажиллах нь бүрэн нээлттэй. Үүнд Их хурлын Тамгын газраас мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. Мөн Засгийн газарт чиглэл өгөх 2 тогтоол баталлаа. Сая чуулганы хугацаанд. Тэр сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой тогтоол. Энхцэцэг гишүүн ажлын хэсгээ ахалж байна. Өчигдөр Үнийн хөөргөдлөөс иргэдийг хамгаалах тухай тогтоол баталсан. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн, Батжаргалын Заяабал гээд гишүүд энэ ажлын хэсэгт ажиллана. Ингээд мэдээж Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газарт тодорхой үүрэг даалгавруудыг тогтоолоор өгсөн учраас парламент хяналтын чиг үүргээ хэрэгжүүлнэ.

Сая гишүүд асуулт асууж байна. Яагаад Татварын багц хуулийг ингэж цаг тулгачхав. 31-ний өдөр энэ 4 хуулийг хэлэлцэж амжих уу гэдэг ийм асуултуудыг гишүүд асуусан. Тэгээд мэдээж жилийн хугацаанд олон нийтийн хэлэлцүүлэг

явуулаад, иргэдийн санал бодлыг цахимаар аваад, бараг 2,7 их наядын иргэдэд учраад байгаа ачааг бууруулах чиглэлээр бас сайтар боловсруулж, олон нийтээс олон саналуудыг бас тусгасан ийм бас хууль, эрх зүйн шинэчлэл татварын шинэчлэл болж байна гэж үзэж байгаа учраас хэлэлцэх эсэхийгээ дэмжээд, Их Хурал дээр ажлын хэсгийг байгуулаад, тэгээд гишүүд чуулганы завсарлагаагаар хуулийн төсөл дээрээ ажиллаад, хаврын чуулганаар баталбал энэ Татварын багц хууль бол зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, иргэдэд, аж ахуйн нэгжүүдэд үүсээд байгаа татварын ачааллыг бууруулахад бас том алхам болно гэж бас үзэж байгаа. Тэгэхээр хэдийгээр 12 дугаар сарын 31-ний өдөр ч гэсэн гишүүд бол хариуцлагатай чуулганыхаа хуралдаанд сууж, энэ татварын ачаалалтай холбогдуулаад санал шүүмжээ хэлж, асуулт асууж, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэн ажил хэрэгч 31-ний өдрийг өнгөрүүлэе гэдэг ийм саналыг дэвшүүлж байна. Санал хураая. Гишүүд танхим цуглая.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д “Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулж, хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ.” гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Одоо хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Тэгээд энэ бол хэлэлцэх эсэхийг дэмжинэ. Тэгэхээр Их Хурлын ажлын хэсэг байгуулагдана. Тэгэхээр ажлын хэсэг бол өөрөө чуулганы завсарлагааны хугацаанд ажиллана гэсэн үг. Хэлэлцэх эсэхийг дэмжих буюу хэлэлцэхийг дэмжих үү гэж үзэл баримтлалын хүрээнд л дэмжиж байна. Тэгээд дараа нь бол анхны хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулаад, тэгээд явна гэсэн үг. Түрүүн Уянгахишиг гишүүн бас горимын санал гаргаад байсан. Бямбацогт дарга та нэг тайлбар хэлэх үү. Үндэслэлээ тайлбарлаарай Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Тэгээд бас нэг жоохон ойлголтын зөрүү байх шиг байна. Засгийн газар энэ Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль гээд энэ хуулиуд дээр бүтэн жилийн хугацаанд хэлэлцүүлэг хийсэн. 200 гаруй мянган санал авсан. 200-аад хэлэлцүүлэг хийсэн. Ингээд өргөн барьж байгаа юм. Энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь өнөөдөр шийдээд, Их Хурал ажлын хэсэг байгуулаад, энэ хаврын чуулган хүртэлх, чуулган завсарласан намрын чуулганаас хаврын чуулган хүртэлх хугацаанд ажлын хэсэг маш сайн ажиллаад, дахиж хэлэлцүүлэг

хийгээд ингээд шийдэх боломжийг бий болгож байгаа. Ингээд 3 сард хэлэлцээд эхлэх юм бол бид нар 7 сардаа баталж амжина.

Хэрвээ одоо өнөөдөр хэлэлцэх эсэхийг шийдэхгүй, 3 сард өргөн бариад хэлэлцэж эхлэх юм бол 10, 11 сард батлагдана. Ингэх юм бол 2027 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжих боломжгүй болчих гээд байгаа юм. Тийм болохоор энийг эртхэн хэлэлцэх эсэхийг нь шийдээд энэ хагас жилдээ багтаагаад баталчихъя. 2027 оны 1 сарын 1-ээс эхэлж мөрдүүлье гэж байгаа юм.

Энэ хуулийн өөрчлөлтүүд хийгдсэнээрээ иргэд, аж ахуйн нэгжүүд дээр 2 их наяд 700 тэрбум төгрөгийн татварын ачаалал буурна. 2 их наяд 700 тэрбум. Иргэдээс Нэмэгдсэн өртгийн албан татвар, Хувь хүний орлогын албан татвар нь хөнгөлөлт эдлээд, 2 их наядын ачаалал буурна. Аж ахуйн нэгж дээр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, Нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт, үүгээр 700 тэрбум төгрөгийн ачаалал буурах юм. Ийм л ач холбогдолтой учраас шийдчихье гээд байгаа юм. Иргэд, олон нийт маань үндсэндээ татварын ачаалал маш өндөр байна гэж ярьдаг. Аж ахуйн нэгж 10, Хувь хүнийх 10, нэмэгдсэн өртөг 10 гээд бараг 30-аад хувийн татвартай байна гэж ярьдаг. Ийм бол бодит байдал дээр биш байгаа. Гэхдээ энэ хууль батлагдах юм бол жижиг дунд аж ахуйн нэгжүүдийн татвар дунджаар 5 хувь болно. Дунджаар. Үүнд уул уурхайн компаниуд ерөөсөө хамаарахгүй. Уул уурхайн компаниуд ямар нэгэн хөнгөлөлтүүд байхгүй. Энэ жижиг, дунд аж ахуйн нэгж, иргэдээ дэмжсэн татварын ачааллыг 2 их наяд 700 тэрбумаар буулгах ийм хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг нь өнөөдөр шийдчихээд, ажлын хэсэг байгуулж байгаад энэ чуулганы завсарлагааны хугацаанд маш их олон хэлэлцүүлэг явуулъя, туршлага судалъя, ингэж байгаад хавар баталъя. Энийг л боломж олгоод өгөөч гэсэн учраас яаралтай горимоор оруулж ирж байгаа юм. Хэрэв одоо шийдэхгүй бол 2027 оны 1 сарын 1-ээс хэрэгжихэд жоохон хэцүү болчих юм. Хаврын чуулганаар батлагдах боломжгүй болчих гээд байгаа юм гэдгийг та бүхэн. Том хууль учраас татварын багц маш том шинэчлэл учраас энэ бол түүхэндээ байхгүй том шинэчлэл. Тийм учраас энэ хаврын чуулгандаа багтахгүй болчих гээд байгаа учраас хэлэлцэх эсэхийг нь шийдье гэж байгаа юм.

Нөгөө шинэ жилээр далимдуулж батлуулах гэж байгаа юм огт биш шүү. Батлуулах гэж байгаа юм ерөөсөө биш. Энэ зөвхөн хэлэлцэх эсэхийг нь шийдээд, 7 сард батлагдах хууль юм.

Н.Учрал: Мэндчилгээ танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Саранчулууны урилгаар “Ахиллис Монгол клуб”-ийн гишүүд, Марафоны тамирчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байн. Та бүхэнд биеийн тамир, спортын өндөр амжилтыг хүсье. Шинэ оны мэнд дэвшүүлье.

Жавхлан сайд одоо энд ингээд 4 хууль байгаад байгаа байхгүй юу. Эсвэл ажлын хэсэг байгуулаад, нийгмийн хэлэлцүүлэг өрнүүлье гэвэл Татварын ерөнхий хуулиа ч юм уу хэлэлцэх эсэхээ дэмжчих тийм гарц байна уу Жавхлан сайд.

Б.Жавхлан: Их Хурал дарга аа баярлалаа үг хэлэх боломж олгосонд. Би яг тийм санал хэлэх гээд байна л даа. Одоо 4 хууль байгаа. Сүүлийн 2 жил гаруйн хугацаанд олон нийтээр хэлэлцүүлэг хийсэн. Энэ жил төсөв өргөн барихтай зэрэгцээд 9 сарын 1-нд бүтнээр нь өргөн барьсан байгаа 4 хуулиа. Ингээд legalinfo дээр байж байгаа. Бүтэн сүүлийн 4 сар Их Хурлын гишүүд, олон нийтэд албан ёсоор дэлгэчихсэн байгаа ийм хууль шүү. Тэрнээс биш гэнэт өчигдөр боловсруулаад,

өнөөдөр орж ирж байгаа зүйл огтоос биш. 1 сар гараад Их Хурал бас үргэлжлэх болов уу гэсэн өнөөдөр ингээд хэдүүлээ завсарлах гэж байгаа учраас хэлэлцэх эсэхээ л шийдэх гэж байгаа шүү дээ яаралтайгаар. Тэрнээс биш баталж дуусгах гэж байгаа асуудал ерөөсөө биш.

Хэрвээ үнэхээр өнөөдөр амжихгүй гэж байгаа бол яг саяын таны хэлсэнтэй би ижилхэн санал хэлэх гээд байгаа юм Их Хурлын дарга аа. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай яг нөгөө суурь хуулиа яаралтайгаар хэлэлцэх эсэхээ эндээ хэлэлцээд, тэгээд ажлын хэсэг нь байгуулагдаад, хавар болтол энэ завсарлагаагаар бүгдээрээ Татварынхаа хуулийг тойроод ажилтай байя л гэдэг ийм л санаа хэлэх гэсэн юм. Тийм зарчмын зөрүүтэй санал хураалгаж өгнө үү.

Н.Учрал: Ганхуяг гишүүн та чинь юу билээ. Та ажлын хэсгийн ахлагч байсан юм уу. Тэгвэл Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Үгүй ээ, энэ Их Хурлын гишүүд яг энэ хуулийн боловсруулалтын шат, хэлэлцүүлгийн шатанд маш идэвхтэй ажилласан шүү дээ. Энэ чинь Их Хурлаас 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаад, Засгийн газартайгаа хамтраад өнгөрсөн хаваржингаа, зунжингаа хэлэлцүүлэг хийчихсэн хууль байхгүй юу. Тэгээд энэ чинь манай Батболд гишүүн байна. Таны урд сууж байгаа Ганзориг гишүүн байсан манай ажлын хэсэгт. Ардчилсан намаас 2, 3 гишүүн байсан. Ардын намаас 5 гишүүн байсан. Энэ чинь хэлэлцүүлэг хийгээд, бид нар яарахгүй байж болно гэхдээ ард түмэн яарч байгаа хууль байхгүй юу. 1 хоногийн ч гэсэн өмнө батлуулахыг хүсэж байгаа болохоор яагаад гэхээр хаврын чуулганаар бид нар энийг давхар хэлэлцүүлээд явна гэх юм бол амжихгүй шүү. Харин ч яг энэ чуулганы завсарлагааны үеэр тойрог дээрээ очиж ажиллахдаа Татварын хуулиа ч яриад, татварынхаа хэлэлцүүлгээ хийгээд явах яг энэ боломжит цаг хугацаагаа ашиглах ёстой байхгүй юу. Одоо яг хэлэлцэх эсэх явчхаад, ажлын хэсгээ байгуулаад, ажлын хэсэг нь ажлаа хийх ёстой юм одоо.

Н.Учрал: Засгийн газрын гишүүн санал хэллээ. Одоо горимын санал бас авна. Жавхлан сайд бол бас зарчмын зөв санал гаргаж байна. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал дээрээ хэлэлцүүлгээ явуулаад, ажлын хэсгээ байгуулчихъя. Бусдыг нь бол ердийн горимоор байж болно. Татварын ерөнхий хуулиа тойроод концепцынхоо асуудлыг гишүүд ажлын хэсгээ байгуулаад, завсарлагаагаар бас олон нийтийн саналыг аваад, тусгаад явах нь бол боломжтой. Сая Ганхуяг гишүүн бас хэллээ. Олон гишүүд оролцож байсан. Зөвхөн Засгийн газар гэлтгүй Их Хурал дээр Төсвийн байнгын хороо татвар дээр нэлээдгүй их бас хэлэлцүүлгүүдийг өрнүүлж ажилласан шүү дээ. Ганхуяг гишүүн Төсвийн байнгын хорооны дарга байхдаа. Тэгэхээр зөвхөн Засгийн газрын гэхгүйгээр гишүүд бас оролцсон асуудал. Гэхдээ энэ бол мэдээж цаг тухайд нь шийдэхийг иргэд, олон нийт ч гэсэн хүсэж байна гэдгийг бол бид нар анхаарах хэрэгтэй. Татварын ерөнхий хуулиа Тэмүүжин гишүүн ээ, Татварын ерөнхий хуулиа бид нар энэ дээрээ яаралтайгаар хэлэлцээд, ажлын хэсгээ байгуулчихвал гишүүдийн нөгөө оролцоо хангагдаад явахад бас завсарлагаагаар илүү зохимжтой байж мэдэх юм. Бусад 3 хууль дээрээ бол хойшлуулах арга хэмжээ авбал. Хэрвээ Засгийн газар тийм байр суурьтай байвал Татварын ерөнхий хуулиа л яаралтайгаар өнөөдөр хэлэлцээд, оныхоо өмнө шийдээд, ажлын хэсгээ байгуулчихъя. Тэгээд Ерөнхий хуультайгаа бусад хуулиуд нь нийцэх л ёстой шүү дээ. Тэгээд гишүүдийн санал ч гэсэн тусахад хэрэгцээтэй юм болов уу гэсэн бодолтой байна. Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Засгийн газар Улсын Их Хурлыг яаж хардгийн нэг хандлага л энд харагдаад байгаа байхгүй юу. 3 сайд нь гурвуулаа дэс дараагаар үг хэлээд, Улсын Их Хурлыг зүгээр Засгийн газрын хуулийн хэлтэс шиг бодоод, та нар ингэж ажиллах ёстой гэж тулгаж байгаа юм шиг. Та нар өөрсдөө ажлаа сайн хийгээд, арай эртхэн өргөн барьчихсан бол ийм асуудал өрнөхгүй шүү дээ. Яг 12 сарын 30-нд нь өргөн бариад, 31-ийх нь өдөр гишүүдэд материал нь тараагүй, яг өнөө өглөө энэ материал чинь тарж ирж байгаа шүү дээ. Материал нь тараагүй. Байнгын хороо нь хуралдаагүй, яаралтайгаар гээд. Үйлчлэх гээд хугацаа нь 2027 оны 1 сарын 1. Жилийн дараа үйлчлэх гэж байгаа байхгүй юу. Үнэхээр л ард түмний нуруун дээрээс татварыг нь хөнгөлөх, татварын дарамт ихтэй байна гэж байгаа бол аль жилийн өмнө өргөн барьчихсан байгаа Пүрэвдорж гишүүн болон бусад гишүүн нь өргөн барьчихсан байгаа Нэмүү өртгийн татвартай холбоотой хууль тогтоомжийг яагаад Улсын Их Хурлаар одоо хүртэл хэлэлцэхгүй байгаа юм. Үзэл баримтлал нь 10 хувийн чинь татварыг 5 болгочихъя. 2 нь хэвээрээ байж байг. Уул уурхайгаас бусад бизнес дээр жоохон ч гэсэн нурууг нь тэнийлгээд өгье гэдэг хууль аль эрт өргөн барьсан шүү дээ. Гэтэл Засгийн газар одоо хүртэл дэмжихгүй. Эрх баригч бүлэг одоо хүртэл урагш нь алхуулахгүй. Яг өөрсдийнхөө пи ар-ыг хийх сэдэв дээрээ болохоороо гүйж орж ирчхээд, Улсын Их Хурлыг зүгээр 1 хоногийн дотор шийдвэр гаргаад өг гэж байгаа юм шиг бүр тулгалт хийж байна шүү дээ.

Би Тамгын газраас асуумаар байгаа юм. Хэлэлцэх эсэхийг яаралтай журмаар хэлэлцдэг дэг байдаг юм уу. Яаралтай журмаар гэвэл хуулийг чинь бүтнээр нь хэлэлцэх дэг байгаа шүү дээ. Тэгэхээр д нарыгаа бодохгүй бол Улсын Их Хурлыг зүгээр л хүссэнээр нь бос гэвэл босож байдаг, суу гэвэл сууж байдаг гээд тэгээд ардаа гоё пи ар худлаа хийх гээд, ард түмний нуруун дээрээс татварынх нь дарамтыг багасгах гэж байгаа гэнэ. Үнэхээр татварыг нь багасгах гэж байгаа бол ээлжит бус зарлаач дээ. Тэгвэл 1 сард. Үнэхээр сэтгэл байгаа бол. Тэгээд зарлаач дээ. Зарлах тухайгаа тэгээд ярина шүү дээ. Ардчилсан намын бүлэг дээр энийг чинь хэлэлцэж ч чадахгүй байна шүү дээ. Та нарын энэ босоо, суугаа нөгөө ямар туулай борвиндоо баастай гэдэг билээ. Тэр шиг энэ байдлаас чинь болоод. Зүгээр жоохон ажил хэрэгч санал гаргаад, Улсын Их Хурлыг тулгах биш бүлгүүдтэйгээ ярилцаад, ажил хэрэгч санал гаргаад, ийм асуудал байгаа юм гээд ярилцвал ойлгож болно. Шөнө нь унтаад өөрсдөө дотроо, ханцуй дотроо юм ярьчихаад өглөө нь босож ирээд гэнэт сэрсэн юм шиг. Тэгээд бусдыгаа ингэж тулгаад, энэ тулгалтад орохгүй бол та нар ард түмний эсрэг байгаа гэж пи ар хийх гэж байгаа юм уу бас. Татвараас нь хөнгөлөхгүй эд нар эсэргүүцээд байгаа юм гэж энэ сарынхаа хугацаанд, амралтынхаа хугацаанд ярих гэж байгаа юм уу. Ийм гэнэн, тэнэг, муйхар байж болохгүй шүү дээ.

Улсын Их Хурал чинь харилцан ярилцаж, ойлголцож, нэгдсэн бодлого дээрээ нам харгалзахгүйгээр урагшаа алхах гэж оролддог болохоос биш нэг хэсэг нь өглөө босоод, 1 юм санаж орж ирээд, тэгээд бусад руугаа тулгалт хийгээд, Улсын Их Хурлыг дарамталж байгаа юм шиг яг ийм арга барилаар ажиллаж болохгүй шүү дээ. Өнөөдөр Улсын Их Хурлын чуулган нээгдэхэд Засгийн газрын хурлыг хүлээж байна гээд бид энд зүгээр хийцгүй суулаа шүү дээ. Та нар Улсын Их Хуралд жоохон хүндэтгэлтэй хандаач. Улсын Их Хурал чинь бас олон намын тогтолцоо байгаа шүү дээ. Олон намын төлөөлөл байгаа шүү дээ. Тэр намын бүлгүүдтэйгээ бас жоохон хүндэтгэлтэй хандаач. Энд байгаа төлөөлөгчдийг, ард түмний сонгогдсон төлөөллийг хүндэтгэхгүй байгаа юм чинь гудамжинд гараад бол жүжиг л тоглож байгаа шүү дээ.

Н.Учрал: Их Хурлын гишүүдийн зарчмын байр суурийг хүндэтгэж хүлээж авах хэрэгтэй. Ер нь бол парламент бол бэлэн байсан шүү. Намрын чуулганаас хойш хугацаанд хуулиа хүлээсээр л байсан. Сая ч гэсэн хэлэлцье л гээд хүлээж байсан. Тэрнээс биш хэлэлцэхгүй гэж хэлсэн хүн 1 ч байхгүй. Тэгээд 2 жил гаруй хугацаанд хэлэлцэгдсэн Татварынхаа багц хуулийг хэлэлцэх эсэхээ дэмжээд, завсарлагаагаар ажиллая гэдэг ийм л байр суурийг гишүүн болгон илэрхийлж байсан.

Тэгэхээр сая Жавхлан сайдын хэлж байгаагаар Татварын ерөнхий хуулиа өнөөдөр хэлэлцэх эсэхээ дэмжээд, бусад хуулиудыг хаврын чуулган руу юм уу эсвэл тэр ээлжит бус шаардлагатай бол зарлаад явах нь зохимжтой болов уу гэсэн миний зүгээр гишүүний байр суурь байна. Горимын санал дээрээ тайлбар гаргахгүй. Горимын саналаар санал хураана.

Их Хурлын гишүүний байр суурь бол би хэлсэн. Энэ бол олон намын, 5 улс төрийн нам, эвслээс бүрдсэн парламент. Тийм учраас би бол хуралдаан даргалагчийн үүргийг л биелүүлж байна. Хуралдаан даргалагч бол улс төрийн нам эвслүүдийн тэгш боломжийг л олгох ёстой.

Сая бол Жавхлан сайдын санал арай үнэнд бас ойртож байна шүү. Ер нь бол зарчмын хувьд мэдээж удаан хүлээгдсэн асуудал. Их Хурал ажлын хэсгээ байгуулаад, энэ аж ахуйн нэгжүүдтэй уулзалт хийх ёстой. Яг энэ Татварын багц хуулийн шинэчлэл яг иргэн таны нуруун дахь ачаанаас хэр хөнгөлөх вэ гэдгийг олон нийтэд танилцуулах хэрэгтэй. Сая тэр үл хөдлөхийн 2 хувь шиг санал дээр 100 мянган хүн санал өгөөд байна шүү дээ. Тэгэхээр Татварын багц хууль дээр хэдэн асуудал байна вэ. Тэгэхээр олон иргэд мэдээж саналаа өгөх байх. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд Засгийн газар бол маш их цаг гаргаж ажилласан. Тэрийг би бас өөрөө бас Засгийн газрын гишүүн байсны хувиар бүрэн ойлгож, мэдэрч ойлгож байгаа.

Тэгээд Ганхуяг гишүүн Төсвийн байнгын хороон дээр ч гэсэн энэ Засгийн газрын Татварын багц хуулийн реформ дээр нэлээдгүй цаг хугацаа гаргаж, олон нийтээс саналуудыг ч авч байсан. Санал хураалтыг явуулна.

Гишүүд түрүүн санал хураалтад бэлтгэсэн. Дахиад сая Засгийн газрын гишүүд нэмж орж ирсэн учраас санал хураалтад бэлтгэх хэрэгтэй байна. Одоо хуулийн төслүүдийг Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Энэ Уянгахишиг гишүүний саналаар санал хураалт явуулчихъя. Горимын санал гаргасан юм чинь тийм биз дээ. Тэгээд агуулга нь бол ижилхэн. Тэгээд дэмжихгүй байна уу, дэмжиж байна уу гэдэг агуулга нь ижилхэн. Уянгахишиг гишүүн ээ, тэгэхээр энэ төлөвлөгдсөн байгаа санал хураалт бол таныхтай ижилхэн санал шүү дээ. Тэгэхээр энэ дээр нэгтгээд санал хураалтаа явуулчих нь зөв байх. 1 асуудлаар 2 явуулаад яах вэ. Тэгэхээр санал хураалтыг явуулъя. Энэ чинь тус тусад нь хураах ёстой юм.

Тэгэхээр эхлээд Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулна. Санал хураалт. Яах вэ, ер нь бол Татварын ерөнхий хууль дээрээ

дэмжээд, Их Хурлын ажлын хэсгээ байгуулаад явъя гэдэг ийм л байр суурийг хэлээд байна шүү дээ.

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт. 31 гишүүн дэмжиж, 43,7 хувиар санал дэмжигдсэнгүй.

3.Хувь хүний орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана. Санал хураалт. 32 гишүүн дэмжиж, 45,1 хувиар санал дэмжигдсэнгүй.

4.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана. Санал хураалт. 33 гишүүн дэмжиж, 46,5 хувиар санал дэмжигдсэнгүй.

Гишүүд ээ одоо ингэнэ. Энэ бол нэн яаралтай горимоор хэлэлцэх эсэхийг дэмжээгүй гэсэн үг. Одоо Төсвийн байнгын хороо хуралдаад, энэ нэмэлт өөрчлөлт. Тэгэхээр шинэчилсэн найруулга биш. Өнөөдөр Төсвийн байнгын хороо үргэлжлүүлж хуралдаад, Татварын ерөнхий хуулийн хэлэлцэх эсэхийг дэмжээд, чуулганаар оруулж ирье. Тэгээд Татварын ерөнхий хууль дээрээ өнөөдөр хэлэлцэх эсэхээ дэмжье болж байна уу. Тэгэхээр одоо ердийн горимоор Төсвийн байнгын хороо Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийнхөө хэлэлцэх эсэхийг явуулъя. Яагаад гэхээр энэ яаралтай горим бол хууль хоорондын хэлэлцүүлгийн хугацааг багасгаж байгаа болохоос биш энэ яаралтай байлаа гээд ямар ч өөрчлөлт байхгүй.

Тийм учраас Төсвийн байнгын хороог хуралдуулъя гэсэн үг. Тэгэхээр сая Засгийн газраас Жавхлан сайд, Бямбацогт сайд нар саналаа хэлсэн. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Хувь хүний орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татварыг биш, зөвхөн Татварын ерөнхий хуулийнхаа хэлэлцэх эсэхийг Төсвийн байнгын хороо дээр өнөөдөр хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, чуулганаар хэлэлцэх эсэхийг нь дэмжье. Тэгэхээр даргын зөвлөл дээр энэ саналаа оруулаад, чуулган үргэлжилж хуралдаад, Татварын ерөнхий хуулийнхаа хэлэлцэх эсэхийг дэмжихье. Ингээд Татварын ерөнхий хууль дээр ажлын хэсэг байгуулъя. Болж байгаа биз. Наранбаатар дарга.

Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаа үргэлжлүүлье. Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг Төсвийн байнгын хороонд хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлүүлэхээр шилжүүллээ.

Татварын багц хуулийн талаар буюу иргэдэд ирэх ачааллыг бууруулах гэж байгаа энэхүү Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар чуулганы завсарлагаагаар Их Хурлын гишүүд мөн Засгийн газрын гишүүд бол олон нийтэд мэдээлэл өгч, саналуудыг сайтар тусгаж, оролцоог хангаж ажиллах хэрэгтэй. Нэн яаралтай горимоор хэлэлцэх асуудал дэмжигдээгүй тул дараагийн асуудалд орно.

6 дугаар асуудал руу шууд орно. 4 хуулийг нэн яаралтай горимоор хэлэлцэхийг дэмжээгүй.

11.20 цаг.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна. Индэрт урья.

А.Ариунзаяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д Улсын Их Хурлын хяналт шалгалт нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус гэсэн төрөлтэй байхаар заасан бөгөөд мөн хуулийн 8.6-д Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварыг холбогдох шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооноос “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д Байнгын, дэд хороо цаглаварт тусгах саналаа ээлжит чуулган завсарлахаас ажлын 10 өдрийн өмнө Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэхээр заасны дагуу бусад Байнгын хорооноос 28 санал ирүүлснээс 27 саналыг тусгасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд заасан хугацаатай тайлан, илтгэл, мэдээлэл, мөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг тайлагнах, бүх Байнгын хороогоор хэлэлцэх цаглаварт тусгасан болно.

Хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах, хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх, тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх, төсвийн биелэлтийг хянан шалгах, хяналт шалгалтын бусад асуудлыг хэлэлцэх хүрээнд нийт 44 асуудлыг цаглаварт тусгалаа.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж үзсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Асуулт асууж, үг хэлэх гишүүд байхгүй байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа.

Гишүүд танхим цуглая. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалтыг явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 45 гишүүн дэмжиж, 62,5 хувиар санал дэмжигдлээ.

Бейсен гишүүнийг дэмжсэнээр, Баясгалан гишүүнийг дэмжсэнээр, Тэмүүжин гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэн үлдээе. Тогтоолын төслийг баталлаа. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварыг хавсралтаар баталсугай.

2.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байнгын хороодын дарга нарт, мэргэжил арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газарт тус тус даалгасугай.

3.Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгуулах саналаа 2026 оны хаврын ээлжит чуулган завсарлахаас ажлын 10 өдрийн өмнө Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэхийг Байнгын болон дэд хороонд даалгасугай.

Тогтоолын төслийг уншиж танилцууллаа.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын

тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11.27 цаг.

Дараагийн асуудалд оръё.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлуудын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатарын Ганбаатар танилцуулна. Ганбаатар гишүүнийг индэрт урья.

А.Ганбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо боловсруулан 2025 оны 12 сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо тогтоолын төслийг хэлэлцэхдээ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.3, 5.4 дэх хэсгийг тус тус баримтлан хэлэлцсэн болно.

Тогтоолын төслийн талаар хууль санаачлагчид болон Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Байнгын хороодоос урьдчилсан санал авахад давхардсан тоогоор нийт 147 хууль тогтоомжийн төслийг хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар саналаа ирүүлсэн байна. Үүнээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг оруулна гэж заасны дагуу батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан болон Улсын Их Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийгээгүй 27 хууль тогтоомжийг тогтоолын төсөлд нэрлэн заасан болно.

Түүнчлэн хэлэлцүүлгийн шатад байгаа болон хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд тогтоолд нэр заагаагүй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэж байхаар тогтоолын төсөлд тусгалаа.

Тогтоолын төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Батжаргал энэ намрын чуулганаар Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн Төлбөрийн чадваргүйдлийн тухай, Зөвшөөрлийн тухай зэрэг улс орны эдийн засгийн идэвхжил, тэлэлтийг нэмэгдүүлэх, баялаг бүтээгчдэд очиж буй татварын ачааллыг бууруулах, тарифын бус хүндрэл саадыг арилгахад чиглэсэн Баялаг бүтээгчдийг дэмжих багц хуулийн төслийг тогтоолын төсөлд нэрлэн заах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатад байгаа хууль, тогтоолын төслүүдийг үргэлжлүүлэн хэлэлцэж, мөн хаврын ээлжит чуулганы

хугацаанд өргөн мэдүүлсэн төслийг тухай бүрд нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу шийдвэрлэж, хэлэлцэх асуудлын тов, дараалалд оруулах нь зүйтэй талаар тус тус байр сууриа илэрхийлсэн болно.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно. Тогтоолын төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан байгаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Ганбаатар гишүүн баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Сая Засгийн газраас өргөн барьсан Татварын багц хууль яаралтай горимоор хэлэлцэх асуудал дэмжигдээгүй учраас хаврын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад дараах 4 болоод, өчигдөр өргөн баригдсан 1 хууль, ингээд 5 хуулийг нэрээр нь хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах ийм хэрэгцээ шаардлагатай байна. Энийг бас хэлье.

1.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 12 сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл;

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 12 сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл;

3.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Засгийн газраас 12 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төсөл;

4.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Засгийн газраас 2025 оны 12 сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн;

5.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүнээс 2025 оны 12 сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн гэх энэ 5 хуулийг хаврын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад нэмэлтээр оруулах саналтай байна. Санал хураалгаж, шийдэж өгнө үү.

Н.Учрал: Байнгын хороо дээр саналаа оруулаад оруулж ирэх учиртай. Тамгын газраас тайлбар өгөх үү. Бямбацогт дарга.

С.Бямбацогт: Би сая бас Байнгын хорооны дарга Сандаг-Очир даргатай адилхан саналтай байгаа юм. Бид нар бас цаг хугацаа хожье. 1 сарын 1-ээс чуулган хэрвээ хугацаагаараа бол 3 сарын 15 хүртэл нь бараг 3 сар орчим хугацаанд завсарлах нь. Энэ хугацаанд Их Хурлын гишүүд тойрогтоо ажиллана, хууль, тогтоолын төсөл боловсруулна. Их Хурал дээр хэлэлцэж байгаа бас хуулиудаа чанартай, сайн батлуулах тал дээр бас хэлэлцүүлгүүд зохион байгуулна. Нэлээн их боломж гарна. Чуулгантай үед чинь нөгөө бүлгийн хурал, Байнгын хорооны хурал, ажлын хэсгийн хурал, чуулганы хуралдаан гээд 7 хоногийн 5 өдөр үндсэндээ завгүй болчихдог. Чуулган завсарлахаараа энэ рүүгээ илүү төвлөрч, Улсын Их Хурлаар батлуулах хууль тогтоомжоо бас илүү чанартай, илүү амьдрал дээр хэрэгжих бололцоотой болгох ийм бас цаг хугацаа гардаг учраас энэ цагийг ашиглаад сая Засгийн газраас өргөн барьсан Татварын багц хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хүн амын орлогын албан татварын тухай хууль, дээрээс нь бас өчигдөр Ардчилсан намын бүлгээс завсарлага авсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль гээд энэ 5 хуулийг хэлэлцэх асуудлын жагсаалтад 1 дүгээрт оруулж өгөөч. Тэгээд хаврын чуулгандаа яаралтай хэлэлцье.

2 дугаарт нь энэ 5 хууль дээр ажлын хэсэг байгуулж, ажиллуулж өгөөч. Цаг хугацаа хожоод бас чуулган завсарласан хугацаанд ажлын хэсгийн гишүүд маань Их Хурлын гишүүд маань бас нэлээн сайн ажиллаад, хэлэлцүүлгүүд зохион байгуулаад, илүү хуулиа чамбайруулж байх юм бол илүү бас ард иргэдэд, аж ахуйн нэгжүүдэд ээлтэй болгож байвал хурдан хугацаанд хаврын чуулганаар энэ хуулиудыг батлахад бас дөхөм болох байх гэж бодож байгаа юм. Тийм болохоор бас ажлын хэсгийг байгуулах тал дээр бас анхаараад өгөөч ээ гэсэн ийм саналтай, хүсэлтэй байгаа юм.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль ялангуяа их чухал байгаа. Бид бас энэ эдийн засаг жоохон хүндрэлтэй байгаа, ард иргэд, аж ахуйн нэгжүүд нэлээн хүнд байгаа энэ цаг үед илүү бас Улсын Их Хурал, Засгийн газар, Монголбанк бас нэлээн томоохон бодлого явуулж, энэ эдийн засгийн хүндрэлтэй байдлыг даван туулах, санхүү, эдийн засгийн хүндрэлтэй байдлаас гарах, энэ талдаа бас илүү анхаарсан бодлого явуулах тал дээр бас анхааръя. Засгийн газар сая бас энэ эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг ард иргэддээ хүртээх 300 хоногийн төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар бас сая хэлэлцэж, баталсан. Тийм болохоор бас энэ талдаа илүү төвлөрөөд ажиллачихвал энэ хөөсөрсөн хөөс, хэт томорсон, данхайсан төсөв маань бас илүү үр ашигтай, хэмнэлттэй болж, үүний үр өгөөж нь илүү эдийн засаг маань бас хувийн хэвшлээ дэмжсэн болохгүй бол хэт эдийн засагт төрийн оролцоо их байгаа энэ асуудлуудаа шийдэх гээд олон асуудлууд байгаа. Энэ дээр бас Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль их ач холбогдолтой байгаа. Тийм болохоор ажлын хэсэг байгуулаад өгөөч гэж Их Хурлын даргаас хүсэж байна. Хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулаад.

Н.Учрал: Татварын багц хуулийг Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэнтэй холбогдуулаад Их Хурлын даргын захирамжаар Их Хурлын гишүүдээс бүрдсэн ажлын хэсгийг байгуулж, хэдийгээр хэлэлцэх эсэхийг нь дэмжээгүй ч гэсэн чуулганы завсарлагаагаар ажлын хэсэг ажилдаа орох хэрэгтэй. Дээрээс нь Сандаг-Очир даргын гаргасан саналыг бас Төрийн байгуулалтын

байнгын хороо дээр ярилцаад, нэмж оруулах бас шаардлагатай. Одоо чуулганаар бол санал хураах дэг байхгүй байна. Бейсен гишүүн.

Б.Бейсен: Юуны өмнө Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүддээ шинэ оны мэндийг хүргэе. Энэ хаврын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтыг харлаа. Эрүүл мэндийн салбарын талаар 1 ч асуудал ороогүй байна. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, улсын клиникийн эмнэлгүүд, дүүргийн эмнэлгүүд, аймгийн нэгдсэн эмнэлгийн өр зээл гээд хэтэрлээ. Он дамжсан. Энэ нуугдмал байдалд байгаа. Үүнтэй холбоотой эмнэлгийн тусламж, үйлчилгээ цалгардаж байна. Тийм учраас хаврын чуулгандаа энийг оруулаад бас хяналт шалгалт хийгээд, эрүүл мэндийн даатгалын худалдан авалтын үнэлгээний асуудалд өөрчлөлт оруулах юм уу. Тусламж өгч яаж сайжруулах тал дээр яахгүй бол даатгалын хөнгөлөлт гээд байхгүй боллоо. Ард иргэд бүгд төлбөр төлж байна. Тусламж авч чадахаа байсан. Энэ талын асуудал дээр ажлын хэсэг гаргадаг юм уу, аль эсвэл хаврын чуулганаар хэлэлцэж өгөхгүй бол болохгүй байна.

2 дахь асуудал. Манайх нүүрс экспортолдог орон мөртөө сайжруулсан шахмал түлш гаднаас худалдаад авч байгаа. Бүр Хятадын гүнээс 2000 хэдэн зуун км-ээс худалдаад авч байна. Дотооддоо шахмал түлшний үйлдвэр байгуулах асуудлыг хаврын чуулганы эхэндээ хэлэлцээд, ер нь дотоод шахмал түлшээр, сайжруулсан түлшээр хангах асуудлыг шийдэхгүй бол болохгүй асуудал байх шиг байгаа юм. Энийг бас хаврын чуулганы жагсаалтад оруулж өгөөч гэсэн хүсэлт тавьж байна.

Н.Учрал: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлуудын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. 43 гишүүн дэмжиж, 59,7 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг баталлаа.

Тогтоолыг та бүхэнд уншиж танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй.

1/Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

2/“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

3/“Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

4/Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

5/Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

6/Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл;

7/Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

8/Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

9/Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

10/Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

11/“Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

12/Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

13/Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

14/Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

15/Боловсролын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

16/Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд;

17/Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

18/Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

19/Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл;

20/Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

21/Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл;

22/Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл;

23/Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

24/Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд;

25/Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл;

26/“Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

27/“Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлуудын тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

2.Хэлэлцүүлгийн шатад байгаа хууль, тогтоолын төслүүдийг үргэлжлүүлэн хэлэлцэх, мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн энэ тогтоолын 1-д зааснаас бусад хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д заасны дагуу шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт тус тус үүрэг болгосугай.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлуудын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Эцсийн найруулга дээр 1 зүйлийг анхааруулъя. Түрүүний хэлсэн 5 хууль буюу Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүд, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл гэсэн эдгээр 5 хуулийг хаврын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах тал дээр давхар анхаарч өгөөрэй. Протоколд тэмдэглүүлье гэдгийг хэлье.

Мөн Бямбацогт даргын хэлээд байгаа. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль жагсаалтад орчихсон байгаа. 24 дээр. Ашигт малтмалын тухай хууль тухайн үед нь 5.7-оор бас ороод явна гэдэг нь бас энэ тогтоолын төслийн 2 дахь заалт дээр байгаа шүү гишүүд ээ.

Н.Учрал: Энэ Их Хурлын тогтоол дээр Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд шаардлагатай тохиолдолд чуулганаар хэлэлцэх асуудлуудыг тухай бүрд нь батлаад явдаг. Энэ бүрэн эрхийнхээ дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо шаардлагатай хуулийн төслүүд, тогтоолын төслүүдийг батлаад явна. Сандаг-Очир гишүүний саналыг протоколд үлдээе.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11.45 цаг.

Дараагийн асуудалд орно.

Баталсан тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1.3-т Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

1.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

2.“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

3.“Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

4.“Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11.47 цаг.

Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна.

Намрын чуулганы хаалтын үйл ажиллагааг эхлүүлье. Гишүүдийг танхимд урья.

2025 оны намрын ээлжит чуулганы хаалтын үйл ажиллагааг эхлүүлье.

Эрхэм хүндэт ард иргэд ээ, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Сонгуулийн шинэ тогтолцооны үр дүнд улс төрийн таван нам, эвсэл, салбар салбар, сонирхлын олон бүлгийн өргөн төлөөллөөс бүрдсэн 9 дэх удаагийн Улсын Их Хурал хоёр дахь Намрын чуулганаа он солигдох цаг мөчид өндөрлөж байна.

Улсын Их Хурал улирч буй 2025 оны хааж буй намрын чуулганаа дүгнэн цэгнэж, угтан авч буй 2026 оны Хаврын чуулгандаа ахиц амжилтаа бататгаж, алдаа, асуудлаа засаж залруулах учиртай.

Хаалтаа хийж буй 2025 оны намрын чуулган хүний эрх, эрх чөлөөг хангах, хүнд суртал, хууль журмын чөдөр тушаанаас иргэнээ чөлөөлөх бодлого, шийдлийн шинэ гараа боллоо. Ирэх хаврын чуулганаар ард түмний 126 элч төлөөлөгч бид хүний эрх, хүүхдийн эрх, иргэний, улс төрийн, эдийн засгийн эрх, эрх чөлөөг хангахын төлөө ухаан бодлог, мэдлэг чадвараа дайчлан, мэргэжлийн бодлогын мэтгэлцээн өрнүүлэх учиртай.

Их гүрнүүдийн геополитик, энерги, эрчим хүчний эх үүсвэр, худалдаа, технологийн зөрчил мөргөлдөөн хурцадмал нөхцөлд Монгол улсын эдийн засгийн тусгаар тогтнолыг бататгах, Монгол Улсын иргэний эдийн засгийн эрх, эрх чөлөөг дархлах нь Та бидний батлах хууль, барих бодлого, гаргах шийдэл болсон байна.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулган 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал ажлын 75 өдөр чуулж, 14 хууль, 37 тогтоол хэлэлцэн баталлаа. Чуулганы нэгдсэн хуралдаан 36 удаа, Байнгын хорооны хуралдаан 111 удаа, дэд хорооны хуралдаан 10 удаа, хянан шалгах түр хорооны хуралдаан 13 удаа хуралдлаа.

2026 оны улсын төсвийн төслийг урьд өмнөхтэй харьцуулахад эрдэмтэн судлаачид, иргэд, мэргэжлийн байгууллагуудаар хэлэлцүүлсэн нь татвар төлөгчдийн хичээл зүтгэлээр бүрддэг төсвөө илүү нээлттэй, оновчтой болгох, үргүй зардлыг хэмнэх, нүсэр том төрөөс ухаалаг, цомхон бүтээмжтэй төрийг бий болгох, зах зээл дэх хэт оролцоог нь хумих, иргэний эдийн засгийн эрх чөлөөг хангах, хувийн хэвшлийн орон зайг нээхийн төлөө улам тууштай баримтлах шинэ чиг хандлагын эхлэл боллоо. Эмч, багш нарын цалинг ирэх онд үе шаттайгаар 76 хувь, тэтгэврийг инфляцтай уялдуулж 8,6 хувиар нэмэх улсын төсвийг хамтдаа хуульчлан баталлаа. Төсөв тэлж, төр данхайхын хэрээр ард иргэд, аж ахуйн нэгжийн үүрдэг ачаа дарамтыг буулгаж, нурууг тэнийлгэхийн төлөө ухаан бодлоо уралдуулсан төсөв боллоо.

Төр хувийн хэвшлийн түншлэлийн өргөн боломжийн өмнө хөндөлссөн элдэв хязгаарлалтуудыг эрс багасгаж чадлаа. Төсвөөс санхүүжүүлэх боломжгүй, төсвийн зарлагын хязгаарт багтаагүй төслүүд хэрэгжих боломжийг хуульчлах эхлэлийг

тавилаа. Түншлэлийн төсөл сонгон шалгаруулалтын хугацаа 12-18 байсныг 1-6 сар, олон биш нэг шаттай, аймаг, орон нутаг бие даан төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл хэрэгжүүлэх, шийдэх эрхтэй боллоо.

Түлш шатахуунаар 100 хувь хараат, саалиа ч, саваа ч бэлдэж чадаагүй, гадаад хүчин зүйлсээс улбаатай тасалдал хомсдолд нэн эмзэг, өртөмтгий байдлыг багасгах, нөөц бүрдүүлж, урьдчилан сэргийлэх зорилгоор Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийг хэлэлцэж баталлаа.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, босгыг нь намсгаж, болзлыг зөөллөлөө. Давтамж нь өссөөр буй ган зуд, гамшигт үзэгдлийн хор хохирлыг бууруулах, малчид нөхөн төлбөрөө нэг удаа урьдчилан авах боломжийг хуулиар бүрдүүллээ.

Улсын Их Хурлын соёрхон баталсан Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулсан зээлийн хэлэлцээр бол “Зүрх судасны үндэсний төв”-ийг барьж босгох, тоног төхөөрөмж, эмч, эмнэлгийн ажилтнуудаа сурган бэлтгэхэд зориулагдах хөрөнгө мөнгө юм. Монгол хүний элэг бүтэн амьдралыг хөнөөх хамгийн түгээмэл шалтгаан зүрх судасны өвчинтэй тэмцэхэд энэхүү зээл зарцуулагдана.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг соёрхон баталж, ногоон болон дижитал шийдэлтэй 32 шинэ сургууль, 9 шинэ цэцэрлэг үүдээ нээж, 38,000 гаруй хүүхэд дэлхийн стандартаар Монголд суралцах боломжийг бүрдүүллээ.

Эрхэм гишүүд ээ,

Энэ намрын чуулганаар бид “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэлэлцэж баталлаа. Хөгжлийн үндсэн чиглэл хүсэл мөрөөдлийн жагсаалт бус хэлэлцэн батлах хуультай, журамтай, бодлогын баримт бичиг боллоо. Тавьсан зорилго, хүрэх арга зам, хэмжүүр шалгууртай замын зураг байж чадлаа. “Хүний хөгжил”, “Нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл”, “Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил”, “Байгаль орчин, ногоон эдийн засаг”, “Төрийн бүтээмж, засаглал”, “Бүсийн хөгжил”, “Үндэсний өрсөлдөх чадвар”, “Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун” гэсэн бодлогын 8 чиглэлээр үндэсний 10, салбарын 37, төсвийн ерөнхийлөн захирагчийн 87, хөтөлбөрийн 228 үр дүнг хүрэх арга замтай нь тодорхойлсон. Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг үнэлэх, ахиц дэвшлийг хянах, зорилтот үр дүнд чиглүүлэх зорилгоор үр дүн тус бүрийг хэмжих нийт 512 шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшнийг тодорхойллоо.

Цаашид үндсэн чиглэлийг хэлэлцэхэд хөгжлийн бодлогын төлөвлөлт, төсөвлөлт болон гүйцэтгэлийн үнэлгээ, хэрэгжилтийн явцыг танилцуулах, тайлагнах, Улсын Их Хурлаар хэлэлцэх хуулийн зохицуулалтын зөрүүтэй байдал,

хэрэгжилтийн үнэлгээний тодорхойгүй байдал, мөн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлалыг хуульчлах зэрэгт Улсын Их Хурал онцгой анхаарал хандуулах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэе.

Ард түмний шийдвэрээр төрийн дээд эрх барьж буй парламентын баталсан хууль, бодлого цаасан дээр биш бодит амьдралд хэрэгжиж байх ёстой. Хууль хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавих нь Улсын Их Хурлын Онцгой бүрэн эрх. Иргэн нь мэдэх эрхээ эдэлж байгаа цагт, олуулаа нүдээр харж байгаа бол, иргэдтэйгээ цуг засаглаж байгаа нөхцөлд эрүүл нийгэм бүрдэн төлөвшдөг. Төр түмэн нүдтэй гэж хэлдэг үгийн утга шим ч үүнд оршдог.

“Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангах, эх орныхоо эрдэнэс баялгийн жинхэнэ эздийнх нь хүртэх үр өгөөжийг өсгөж нэмэх үндсэн зорилготой Хянан шалгах түр хороо бүрэлдэн ажиллаж, нээлттэй сонсгол зохион байгууллаа. Түр хороо 6 сарын туршид ажиллаж, хяналт шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж, хэлэлцүүлэн батлууллаа. Засгийн газар гадаадын хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж байгаа цаг үетэй давхцан батлагдсан энэхүү тогтоолд Монголын талын хүртэх үр өгөөжийг 53 хувиас доошгүй байхыг баталгаажууллаа. Түүнчлэн “Жавхлант”, “Шивээ толгой” ордын ашиглахад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг баримтлан, үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд оногдох үндсэн зарчмыг хангахуйцаар төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ирээдүйд Монголын талд үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавартай хөрөнгө оруулалт, санхүүгийн үүрэг, эрсдэл хүлээхгүй байх нөхцөл бүрдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгалаа.

Эцэст нь дүгнэхэд, дэлхийд томд тооцогдох Оюу толгой бүлэг ордын холбоотой Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баримтлах бодлогыг тодорхойлсон түүхэн шийдвэр боллоо.

Хяналт шалгалт, нээлттэй сонсголыг зохион байгуулж, тууштай, зоригтой манлайлан ажилласан Отгоншарын Батнайрамдал даргатай, Улсын Их Хурлын хянан шалгах хорооны гишүүд, шинжээч, хянан шалгагч нарт баялгийнхаа эзэн байх бүрэн эрхтэй бүх монголчуудынхаа өмнөөс баяр хүргэж, талархал илэрхийлье.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа нь улсын хил хязгаар, газар нутгийн бүрэн бүтэн байдал төдийгүй эдийн засгийн тусгаар тогтнол, аюулгүй байдал билээ. Эдийн засгийн тусгаар тогтнол бол улсын тусгаар тогтнолын тулгуур баганын нэг. Улс орны эдийн засгийн тусгаар тогтнолын эш үндэс, эд эс нь иргэний эдийн засгийн эрх чөлөө. Улс төрийн эрх чөлөөний баталгаа дархлаа нь иргэний эдийн засгийн эрх чөлөө.

Ирж буй 2026 оны Хаврын ээлжит чуулган иргэнээ хүнд суртал, хууль журмын чөдөр тушаа, төрийн зуршлыг халж, хувийн хэвшлээ чөлөөлөх, бизнес, хөрөнгө оруулалтын эрх зүйн эрүүл цэвэр үндэс хөрсийг суулгах хаврын тариалалтын өдрүүд байх болно.

Монгол Улсын Их Хурлын даргын бүрэн эрхийнхээ дагуу захирамж гарган, Үндсэн хуульд заасан үндсэн эрх, эрх чөлөөг хааж боосон, хавчиж хязгаарласан хүнд суртал, хууль журмын хийдэл давхардал, гох дэгээ, төрийн хэтийдсэн оролцооноос иргэнээ, хувийн хэвшлүүдээ чөлөөлөх “Чөлөөлье” санаачилга боловсруулан дэвшүүллээ. “Чөлөөлье” санаачилгыг бодлого, хөтөлбөр, бодит үр дүн, өөрчлөлт болгон амилуулах зорилгоор Улсын Их Хурлын 12 гишүүнээр ахлуулсан ажлын хэсгийг байгууллаа.

Үндэснээсээ тусдаа навч ургадаггүй боловч салбар салбарт эдийн засгийн эрх чөлөөг тушиж ургасан мөчир салаа, бизнесийн орчныг муутгасан хүчин зүйлс, хууль тогтоомжийн хийдэл, давхардал, хийдэл, зөрчил, засаглал, авлига, хүнд суртал, хуулиас давсан дүрэм журмууд, хүний хүсэлд хясал болсон бодит байдлыг оношлон дүгнэж, гарц шийдэл, орц жорыг санал болгож, хууль тогтоомжийн төслийг боловсруулах болно.

“Чөлөөлье” санаачилгыг амилуулж, төрийн бодлого шийдэл болгосон эхний дорвитой алхам нь Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байлаа. Ирэх хаврын чуулганаар хэлэлцэх энэ хуулиар зөвшөөрөл нэртэй ч хориглолт, авлигын хөрс тэжээл болж, хүний хүслийг хяссан хүнд суртлын хана хэрэм, шат дамжлага, зүс нэрээ өөрчилсөн элдэв төрлийн саад тээгийг нэг мөр хуульчлан цэвэрлэхийг зорьж байна. Хориглоогүй бол зөвшөөрөгдөж, 30 гаруй үйл ажиллагааг төрийн шийдвэрийг хүлээлгүй шууд мэдэгдээд эхлэх эрхийг хуулиар нээх болно.

Монгол Улсын Засгийн газраас Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төслийг Хөрөнгө оруулалтын болон бусад хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтийн хамт Их Хуралд өргөн барилаа. Өмчлөх эрх бол хүний үндсэн эрх. Өмч хөрөнгийн халдашгүй байдал, чөлөөтэй бизнес эрхлэх, иргэн, компани, аж ахуйн нэгжийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх, хуулийг ашиггүйгээр буцаан хэрэглэхгүй байх нь хөгжил дэвшлийн хөрс. Эдийн засгийн хүндрэл зөвхөн түүхий эдийн үнэ унаснаас бус иргэндээ үл итгэх, зааж зааварлах, хааж хясах, хийх ёсгүйгээ мэддэггүй төрийн хэт оролцооноос үүдэлтэй үнэнийг хүлээн зөвшөөрөхөөс эхлэн бид энэ асуудлыг даван туулна. Эдийн засаг, бизнесийн харилцааг ганц хуулиар зохицуулах боломжгүй. Олон улсын нөхцөл байдал, технологи, хиймэл оюуны өндөр хурдтай хөгжлийн эрин үед цаг үеэсээ хоцрохгүй байх, салбар дундын хуулиуд гарах хэрэгцээ шаардлага тухай бүрд үүсэж байна. Өдрөөс өдөрт өөрчлөгдөж байгаа өндөр хурдны өөрчлөлт үед хууль тогтоогч Та бүхэнд бизнес эрхлэгч, баялаг бүтээгчид, эдийн засгийн эрх чөлөөний итгэлтэй хамгаалагчид болж ажиллахаас өөр гарц үлдээгүй.

Бизнесийн эрх зүйн харилцааны чухал дэд бүтэц болох дампуурлын буюу төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг үр дүнтэй зохицуулж, хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчдийн итгэлийг хамгаалах, эрсдэлийг бууруулж, урьдчилан сэргийлэх, дахин хөрөнгөжүүлэх, бүтцийн өөрчлөлт хийх, санхүү, зах зээлийн харилцааны ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх, хуулийн хүрээнд “өр төлбөрөөс” чөлөөлөх зорилгоор Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэлээ.

Төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг бид хатуу баримтлах ёстой. Үүний тулд эрх зүйн орчныг бүрдүүлж, зах зээлд оролцогчдод “тоглоомын дүрэм”-ийг тодорхой, ойлгомжтой болгох шаардлагатай. Тоглоомын дүрэм тодорхойгүй бол шоглоомын дүрэмгүй дүрэм болдог. Хувийн хэвшлийн орон зайд төр бизнес хийхгүй, хуульд заасан “хуруу дарам” үндэслэлээр төрийн өмчит байгуулахгүй. Юм бүхнийг хийдэг биш, юу хийхгүйгээ мэддэг төр эрүүл байна. Хөрөнгө өмч ихтэй төр биш цомхон цэвэрхэн төр илүү хүчтэй. Төр зохицуулагч болохоос бус төр өрсөлдөгч биш. Төр хуулиар зохицуулж, стандарт тогтоодог болохоос бус өөрийн тоглоомын дүрмээрээ хувийн хэвшилтэйгээ, иргэнээсээ илүү давуу эрхтэй бизнесийн өрсөлдөгч, зах зээл, ашиг орлого булаагч биш. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж, шийдвэрлэх нь энэ парламентын хамгийн том “чөлөөлөлт”-ийн нэг байх болно.

Цаашид бизнес эрхлэгчдийн ашгийн төлөө зорилгыг дэмжих, гэрээнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, үүссэн хэрэг маргааныг нь түргэн шуурхай, иргэний хэрэг маргаанаас ялгаатай, онцлог журмаар шийдвэрлэх, бизнесийн ёс зүй, хариуцлагыг төлөвшүүлэх хүрээнд Арилжааны хууль, бизнесийн гэрээ хэлцлийн хэрэгжилтийг баталгаажуулж, төлбөр төлөх уян хатан хөшүүргийг олон улсын сайн жишигт нийцүүлэн бий болгох, үр дүнтэй, шуурхай иргэний шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоог бүрдүүлэх хүрээнд хувийн эрх зүйн шинэчлэлийг ирэх хаврын чуулганаар хийх шаардлагатай байгааг онцлон тэмдэглэе.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд, бизнес эрхлэгч, иргэн, эрдэмтэн судлаачид хэн бүхэн “Чөлөөлье” санаачилгыг амилуулж, мэдлэг оюун, мэргэжил чадвар, санал бодлоо уралдуулж, илүү сайхан амьдрах хүслийг хяслаас чөлөөлөх, эдлэх ёстой жам ёсны заяамал эрхээ эдлэхийн төлөө идэвх санаачилгатай ажиллана гэдэгт итгэл төгс байна.

Парламентын албан ёсны цахим хуудаст D-Parliament: AI Дүн шинжилгээ цэсийг нэмж, 378 хуульд AI шинжилгээ хийх ажлыг эхлүүллээ. Технологийн дэвшлийг хүний эрх, хүний сайн сайхны тусын тулд хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хуулийн төслийг боловсруулахад ашиглаж эхэллээ. Өчигдөр Монгол Улсад анх удаа робот мэс засал хийж хүний амь аварсан шиг технологийн дэвшлийг хүчин төгөлдөр 378 хууль дахь хүний эрхийн зөрчлийг арилгахад бид ашиглах болно. Парламентын цахим талбарт гар утаснаасаа зочилж, өргөн барьсан ямар хууль хүний эрхийг зөрчиж, хязгаарлаж болзошгүйг

өөрсдөө шалгах боломж бодитой болсон нь хууль, шийдвэрт иргэний санал бодол, идэвхтэй оролцоог технологийн дэвшлийг бодитой ашиглаж эхэлсэн алхмын нэг байлаа.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолуудад тусгасан эдийн засгийн эрх чөлөөг сайжруулах, үнийн өсөлтөөс иргэдийн орлогыг хамгаалах, төсвийн сахилга батыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Монгол банканд болон Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталлаа. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар инфляц 8.2 хувьтай гарсан нь Монголбанкны 4-8 хувийн зорилтот интервалаас давсан бөгөөд инфляцын дарамт өргөн хүрээнд тэлэхийн хэрээр зээлийн өндөр өсөлт болон 2026 оны цалин, тэтгэврийн бодлогын нөлөө нь эрэлтийн инфляц нэмэгдэх эрсдэл дагуулж, өрхийн бодит орлого буурч, хөдөлмөрийн зах зээл суларч байгаа тул эдийн засаг, инфляцын нарийн тэнцвэртэй бодлого явуулах шаардлагатай байна. Иймд “Иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах арга хэмжээний тухай” 16 багц арга хэмжээ бүхий Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд чиглэл өгөх Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэн баталж, чуулганы завсарлах хугацаанд хэрэгжилтийг хангуулж ажиллахаар боллоо.

Ногоон эдийн засгийг дэмжих, ногоон төслүүдийг хэрэгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийг хөгжүүлэх замаар эрчим хүчний импортын хараат байдлыг бууруулах хүрээнд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталлаа. Нар, салхины хязгааргүй их нөөцтэй Монгол оронд айл өрх сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэж, төвийн шугамд нийлүүлэхэд хүнд суртлын 10 гаруй шат дамжлагаар тээг тавьсныг энэ шийдвэрээр арилгаж байна. Нарны илч гэрлийг хүртэл хүнд суртлаар халхалж байгаа цагт бид боломж, нөөцийг хөгжилд дэвшилдээ ашиглаж чадахгүй. “нэг зуун мянган нарны гэр” хөтөлбөр, орон нутгийн сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжих 100 мвт-ын тархмал эх үүсвэр, автозамын сүлжээ, экспортын боомтуудыг харгалзан 100 байршилд цахилгаан машин цэнэглэх иж бүрэн зогсоол, цогцолбор байгуулах ажлууд энэхүү тогтоод багтсан бөгөөд тэр дундаа 20 квт хүртэлх хүчин чадалтай нарны панель, батарейн системийг техникийн нөхцөл шаардахгүйгээр нэг стандартад нийцүүлэн түгээх сүлжээнд шууд холбож, илүүдэл цахилгааныг сүлжээнд нийлүүлж, орлогыг тухай бүр авах боломжийг бүрдүүлэх чиглэлийг Засгийн газарт өглөө. Иргэнээ хүнд суртлаас “чөлөөлөх” бодит алхам энэ мэт үргэлжлэх болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Алдаа, оноо сургамж бүхэнд соргог байж, иргэд сонгогчдынхоо итгэл, найдварыг өндөрт өргөж, тангарагтаа үнэнч байж, шийдвэр гаргахын чухлыг энэ танхимд суугаа нөхдөдөө дахин сануулъя.

Миний бие Улсын Их Хурлын даргын албанд томилогдоод, сар гаруйн хугацаа өнгөрч байна. Үг уриагаар бус өдөр тутмын үйл ажиллагаагаар олон түмэнд ил тод

байлгахын тулд ирц, явцыг өдөр бүр нээлттэй мэдээлж эхэлсэн. Цаашдаа ч нээлттэй парламентыг бүрдүүлэхэд анхаарч ажиллана. Улсын Их Хурлын гишүүд хурал, чуулганаа таслахгүй оролцохоос үндсэн үүргээ биелүүлэх эсэхийг хэмжих эхний шалгуур эхлэх болно.

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал бол иргэнээсээ давуу, авлига, ашиг сонирхлын гэмт хэрэгт шалгуулахгүй байх тусгай давуу эрх биш гэдгийг дахин сануулъя.

Ард түмний 126 дарга биш ард түмний 126 элч төлөөлөгчид бид нийгмийн хүссэн хүлээлт, хэрэгцээ шаардлага, улс орны эрх ашиг, цаг үеийн хэрэгцээ шаардлагыг нарийн мэдэрсэн, хүний эрхийн бодлогын өмгөөлөгчид, иргэнийхээ улс төр, эдийн засгийн эрх чөлөөний хамгаалагчид байх үүрэгтэй.

Иргэн баян бол улс баян. Эрх чөлөө бол хэн нэг эрх мэдэлтэн олгодог зөвшөөрөл, бэлэг огт биш. Эрх чөлөө бол иргэн бүрийн хайрлан хамгаалж, нандигнан бататгадаг эрхэм нандин үнэт зүйл.

Эрх чөлөөт Монгол Улсын иргэн бүрийн эдлэх ёстой эрх, эрх чөлөөг дархлахын төлөө хамтдаа хичээн зүтгэцгээе.

Эрх чөлөөний нар хүн бүрийг алагчлалгүй ивээх болтугай.

Та бүхэндээ шинэ оны халуун дотно мэндчилгээг өргөн дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулган хаасныг мэдэгдье.

12.10 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ